



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 201 дугаар тушаал, “Санар ҮЦК”, “Монсек ҮЦК”, Масдак ҮЦК”, “Булган брокер ҮЦК” хязгаарлагдмал хариуцлагатай компаниудын арилжаанд оролцох эрхээ сэргээлгэх тухай хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Санар ҮЦК”, “Монсек ҮЦК”, Масдак ҮЦК”, “Булган брокер ҮЦК” ХХК-иудын арилжаанд оролцох эрхийг 2015 оны 1 дүгээр сарын 6-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг тушаалын 1-т заасан үнэт цаасны компаниудад анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР